

иргэдэд үйлчилж, ажлын байранд бөөгнөрөл үүсгэхгүй байхаар зохион байгуулж ажиллахыг Банкны захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

7. Дээрх хугацаанд халдвар хамгааллын дэглэмийг баримтлан нийтийн эзэмшлийн гудамж, талбай, цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн тоглоомын талбайд бөөгнөрөл үүсгэхгүй, дэлгүүр, эмийн сан, эмнэлгийн үйлчилгээ авахаас бусад тохиолдолд гэрээсээ гарахгүй байхыг нийт иргэдэд үүрэг болгосугай.

8. Халдвар хамгааллын дэглэмийг мөрдөн, нийт ажиллагсдын 10 хүртэл хувийг ажлын байранд ажиллуулах, төрийн албан хаагчдыг гэрээсээ ажиллах нөхцөлийг хангах, төрийн үйлчилгээ, мэдээ, мэдээллийг цахимаар хүргэх, иргэн, аж ахуйн нэгжийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэн ажиллахыг нийт байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

9. Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Сувданцэцэг/-т үүрэг болгосугай.

10. Худалдаа, үйлчилгээний байгууллагуудын халдвар, хамгааллын дэглэмийг мөрдөж байгаад, хүргэлтийн хүнс, барааны чанарт хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн /Д.Эрдэнэтулга/-д үүрэг болгосугай.

11. Уул уурхайн олборлолт, зам барилга, дэд бүтэц, хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ажилчид болон нийслэл, бусад орон нутгаас ирсэн ажилтнуудад халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн ажиллуулахыг аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Ч.Сугармаа/-д үүрэг болгосугай.

12. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд сул болон өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглож, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч /Б.Шинэбаяр/, Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн /Д.Эрдэнэтулга/, 1, 2 дугаар багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.


13. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн /Д.Сувд-Эрдэнэ/, Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч /Б.Шинэбаяр/ нарт үүрэг болгосугай.

14. Холбогдох хууль, дүрэм, журам, түр заавар, бусад эрх зүйн актыг зөрчсөн төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэдэд хуулийн дагуу хариуцлага тооцох, шаардлагатай тохиолдолд хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч /Б.Шинэбаяр/, Мал эмнэлгийн улсын байцаагч /Ш.Буяннэмэх/ нарт үүрэг болгосугай.

15. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг тухай бүрт тайлагнаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Отгонжаргал/-д, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч /Ч.Сугармаа/-д үүрэг болгосугай.


16. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/56 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын 2021 оны 04
сарын 25-ны өдрийн 1166 дугаар
захирамжийн хавсралт




Хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэдийн зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны жагсаалт

| № | 1. Төрийн байгууллагын үйл ажиллагаа |
|------------------------------------|---|
| 1.1 | Төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага /нийт ажилтан, албан хаагчийн 10 хүртэл хувь ажиллах, цагийн хязгаар тогтоох/ |
| 1.2 | Эрүүл мэндийн байгууллага |
| 1.3 | Тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд /Байгаль орчныг хамгаалах, улсын бүртгэл, цагдаа |
| 1.4 | Эрчим хүч, дулаан, усан хангамж |
| 1.5 | Шуудан, харилцаа холбоо |
| 1.6 | Зайны сургалт, хүүхэд хамгааллын үйлчилгээ, халамж, улаан загалмайн анхан шатны хороо |
| 1.7 | Газар тариалан, мал, амьтны өвс, тэжээлийн түгээлт, тээвэрлэлт |
| 1.8 | Нотариат |
| 1.9 | Банк, цахим банк, автомат тооцооны машин (Ажлын байранд нийт ажиллагсдын 10 хүртэл хувийг ажиллуулах, цагийн хязгаар тогтоох) |
| 2. Хуулийн этгээдийн үйл ажиллагаа | |
| 2.1 | Эрчим хүч, дулаан, усан хангамж, ариутгал |
| 2.2 | Эрүүл мэндийн байгууллага, эмийн сан, эм эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх |
| 2.3 | Шуудан, харилцаа холбоо, илгээмж |
| 2.4 | Шатахуун, түлшний хангамж |
| 2.5 | Улсын Онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хангах аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа /эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр/ Уул уурхай |
| 2.6 | Газар тариалан, мал, амьтны өвс, тэжээлийн түгээлт, тээвэрлэлт |
| 2.7 | Хүнс, ахуйн хэрэглээний үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэл, түгээлт, ханган нийлүүлэлт |
| 2.8 | Оршуулга, буяны үйл ажиллагаа |
| 2.9 | Харуул, хамгаалалтын байгууллага /Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй/ |
| 2.10 | Ариутгал, халдваргүйжүүлэлт, хог хаягдлын цэвэрлэгээ, ачилт, цуглуулалт, тээвэрлэл |
| 2.11 | Орон сууц, нийтийн үйлчилгээний контор, СӨХ |
| 2.12 | Банк, цахим банк, автомат тооцооны машин (Ажлын байранд нийт ажиллагсдын 10 хүртэл хувийг ажиллуулах, цагийн хязгаар тогтоох) |
| 2.13 | Барилгын материалын худалдаа |
| 2.14 | Дугуй, автомашин засвар |
| 2.15 | Хоол хүргэлт |
| 3. Иргэдийн үйл ажиллагаа | |
| 3.1 | Эмнэлгийн зайлшгүй тусламж, эмийн сан |

16. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/56 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ